| 7.1.10 | Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хууль 6 дугаар зүйлийн 6.1.8;<br>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2 | Эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ыг томилсон байх, урамшуулал өгдөг эсэх | 0-4 | ГЕГ-ын даргын 2014 оны 4 дүгээр сарын 9-ны өдрийн А/65 тоот тушаалаар Гаалийн газар, хороодын албан хаагчдын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэж, хүлээж авах эрх бүхий албан тушаалтныг томилсон. Уг тушаалаар ЭБАТ-д хувь хүний нууцтай холбогдох мэдээллийн хадгалалт, хамгаалалтын байдал, тогтвортой ажиллах нөхцлийг хангах, цалингийн урамшуулал олгохоор үндсэн цалингийн 10 хувийн нэмэгдэл олгохыг СХОХ-ын даргад зөвшөөрсөн.<br>Мөн https://meduuleg.iaac.mn/AOS/ бүрдүүлэлтийн програмд бүртгэн эрх нээн ажиллуулж байна. |
| | | ЭБАТ-ын гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгасан байх | | ЭБАТ-ын гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарийг тусгасан болно. Зураг-51<br><br>АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ<br>А.ТАНИЛЦУУЛГА<br>1.Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар / 2.Нэгжийн нэр: Төрийн захиргаа, удирдлагын газар<br>3.Ажлын байрны нэр: Хөрөнгө, орлогын мэдүүлэг хариуцсан гаалийн улсын байцаагч / 3.1.Албан тушаалын ангилал: Туслах түшмэл / 3.2.Албан тушаалын зэрэглэл: ТТ-12<br>4.Ажлын байрыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга; Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга; Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсын ахлах байцаагч / 4.1. Албан тушаалын нэр: Ахлах түшмэл; Ахлах түшмэл; Дэс түшмэл / 4.2. Албан тушаал эрхлэгчийн тоо: ТТ-16; ТТ-16; ТТ-14<br>5.Ажлын байрны шууд харьяалан удирдах албан тушаал: / 5.1. Албан тушаалын нэр: / 5.2. Албан тушаал эрхлэгчийн тоо:<br>Б. ЧИГ ҮҮРЭГ<br>1.Ажлын байрны зорилго: Гаалийн байгууллагын албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг, мэдэгдэл, урьдчилсан мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих, тайлагнах, хадгалах, авлигаас ангид байх, хүний эрхийг хангах арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах<br>2. Ажлын байрны үндсэн зорилт: 1. Албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг, мэдэгдэл, урьдчилсан мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих, тайлагнах, хадгалах 2. Гаалийн байгууллагын хэмжээнд авлигаас ангид байх, хүний эрхийг хангах арга хэмжээг зохион байгуулах, тайлагнах / 2.1. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт: 1.Мэдүүлэг, мэдэгдэл хууль, журмын дагуу бүртгэгдэж, тайлагнагдсан байна. 2.Байгууллагын хэмжээнд авлигаас ангид байх, хүний эрхийг хамгаалах арга хэмжээ тогтмолжиж, төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.<br>3. Ажлын байрны гол үйл ажиллагаа: Ажлын байрны 1 дүгээр үндсэн зорилтын хүрээнд: -Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдүүлэг, мэдэгдлийн талаар холбогдох эрх зүйн актуудыг сурталчлах, байгууллагын ажилтнуудаар судлуулах; -Албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг, мэдэгдэл, урьдчилсан мэдүүлгийг гаргахтай холбоотой заавар, зөвлөгөө өгөх; -Албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө,орлогын мэдүүлэг, мэдэгдэл, урьдчилсан мэдүүлгийг бүртгэж хүлээн авах; -Мэдүүлэг, мэдэгдэл засваргүй, бүрэн гүйцэд бөглөгдсөн, хугацаандаа өгсөн эсэхэд хяналт тавьж, мэдүүлгийг зохих журмын дагуу гаргаж өгөхийг шаардах, хууль зөрчсөн гэх / 3.1. Хугацаа, хувиар<br>60<br>ЭБАТ-ын ажил үүргийн хуваарьт:<br>- Гаалийн улсын байцаагчийн ёс зүй, сахилгын дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих, холбогдох судалгаа, дүн шинжилгээ хийх, санал боловсруулах, удирдлагыг мэдээллээр хангах<br>- Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдүүлэг, мэдэгдлийн талаар холбогдох эрх зүйн актуудыг сурталчлан таниулах, заавар, зөвлөгөө өгөх<br>- Албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг, мэдэгдэл, урьдчилсан мэдүүлгийг шалган бүртгэж хүлээн авах, хадгалах, тайлан мэдээ гаргаж хүргүүлэх<br>- Гаалийн байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх авлигаас ангид байх арга |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | хэмжээний төлөвлөгөө боловсруулж батлуулах, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, хийсэн ажлын тайланг нэгтгэн дүгнэх, удирдлагад танилцуулах, холбогдох газарт хүргүүлэх<br>- Гаалийн байгууллагын хэмжээнд авлигын эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах, шалгалтын мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх<br>- Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах зэргийг тусгаж өгсөн. |
| | | Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байх | | 2014 оны 1 дүгээр сарын 3 болон 8-ны өдөр Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт дүн шижилгээний хэлтсээс зохион байгуулсан “ЭБАТ-тай ярилцах цаг” сургалтанд тус газрын ЭБАТ ГУБ Р.Болормаа хамрагдсан.<br>Төрийн болон нутгийн захиргааны төв байгууллагын мэдүүлгийг хянах, бүртгэх хадгалах эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан “ЭБАТ-тай ярилцах цаг” нэгдсэн сургалт, хэлэлцүүлэг Авлигатай тэмцэх газрын байранд 2014 оны 5 дугаар сарын 9-ны өдөр болж гаалийн байгууллагыг төлөөлөн ГЕГ-ын эрх бүхий албан тушаалтан хамрагдлаа.<br>http://www.customs.gov.mn/2014-03-24-06-24-11/2014-03-24-06-25-21/2014-05-22-06-05-49/251-2014-05-22-06-59-16 |
| | | ЭБАТ-ын үйл ажиллагааг үнэлэх | | АТГ /ХШДШХ/-ын үнэлгээ байна |
| 7.1.11 | Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1, 7.1.2, 7.2.4, 7.2.5, 10-22 дугаар зүйл, 29 дүгээр зүйл;<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9, 6.8, 6.1.6 | Ёс зүйн дүрмийн төсөлд Авлигатай тэмцэх газраас өгсөн саналыг тусгасан байх | 0-6 | ГЕГ-ын даргын 534 тоот тушаалаар баталсан “Гаалийн улсын байцаагчийн ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Гаалийн газрын гаалийн улсын байцаагчийн ёс зүй сахилга хариуцлагыг дээшлүүлж, сэтгэлгээний хандлагыг өөрчлөх, төрийн үйлчилгээг гаалийн харилцаанд оролцогчдод хөнгөн шуурхай хүргэх, авлига хүнд суртлаас ангид байх, ажлын байран дахь цаг ашиглалтыг сайжруулах, харилцааны соёл, үйлчилгээний стандартыг төлөвшүүлэх зорилгоор сургалт, мэдээ мэдээллийг зохион байгуулж, гарын авлага тараах, ажлын байранд зурагт хуудас байршуулах, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг гэнтийн үзлэг шалгалтаар шалгах, сар бүрийн гаалийн улсын байцаагчийг үнэлэх, дүгнэх шалгуур үзүүлэлтээр дүгнэн урамшуулах зэрэг хяналт тавин ажиллаж байна. |
| | | Ёс зүйн дүрмийг батлах, мөрдүүлэх /албан хаагчдад танилцуулсан байдал/ | | Ёс зүйн дүрмийг шинэчлэхээр гаалийн газар, хороодоос төсөлд санал авсан. Авсан саналыг нэгтгэн ХЭЗХ-т хүргүүлсэн. ХЭЗХ-ээс ажлын хэсэг дүгнэлт гарган гаргасан төслийг Авлигатай тэмцэх газарт хянуулахаар ажиллаж байна. |
| | | Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөл /*тогтмол утас ажиллуулах, цахим хуудсанд байршуулах, шуудангаар, биечлэн, хайрцаг байршуулах г.м*/- | | Гаалийн байгууллагын хэмжээнд зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах тогтмол утас 1800-1281 ажиллуулж, цахим хуудсанд байршуулж, шуудангаар болон биечлэн, саналын хайрцаг байршуулан тус бүр авч байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | ийг бүрдүүлсэн байх | | |
| | | Зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ /Зөвлөмж/-г авах | | АТГ-аас ирүүлсэн 4 албан тоот, зөвлөмжийн хүрээнд авлигын эсрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллав.<br>1. ГЕГ-т ирүүлсэн зөвлөмж хэрэгжүүлэх талаар<br>2. ГЕГ-т хуулийн хэрэгжилтийг хангах талаар<br>3. Бэлтгэл хангуулах талаар<br>4. Хуулийн хэрэгжилт хангуулах тухай<br>АТГ-аас ирүүлсэн хуулийн хэрэгжилтийг хангах талаарх албан тоотын дагуу холбогдох арга хэмжээг авч ажилласан. |
| | | Зөрчил илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэсэн байх | | Ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл, мэдэгдэл ирээгүй байна. Холбогдох зөрчил үүссэн тохиолдолд ГЕГ-ын ХЭЗХ нь Сахилгын хороогоор хэлэлцэн шийдвэрлэнэ. |
| | | Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хамт олонд мэдээлсэн байх | | Гаалийн байгууллагын удирдлага ГУБ-ын ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг талаар байгууллагын “Мэдээллийн цаг”-аар” хамт олонд мэдээлэл хийсэн. Онлайн шуурхай хуралдаанаар гаалийн газар, хороодын удирдлагаас хариуцсан гаалийн улсын байцаагчдын ёс зүйн хэрэгжилтийн байдалтай танилцдаг. |
| 7.1.12 | Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.6, 19 дүгээр зүйл | Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулсан байх | 0-2 | Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, гаалийн газар, хороодын удирдлагад албан тоотоор хүргүүлсэн. Хариуцсан албан хаагчдад танилцуулан ажилласан. Цахим сайт дээр байршуулсан.<br>Зураг-52<br><br> |
| | | Давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаатай байх, давхар ажил эрхлэх тохиолдолд зөвшөөрөл олгодог байх | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 7.1.13 | Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 9.1.5 | Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байх /цахим хуудсаар/ | 0-4 | Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлэх үүднээс цахим хуудсаар ил тод нээлттэй байршуулсан.<br>Зураг-53<br><br> |
| | | Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамаарууулснаас бусад шийдвэр /тушаал, захирамж/-ийг цахим хуудсандаа байршуулах | | 1. Гаалийн байгууллагын удирдлагаас гаргаж буй бүхий л шийдвэр тушаалын хууль зүйн үндэслэл, бусад хууль тогтоомжтой нийцэж буй байдал, хууль тогтоомж зөрчиж буйд ГЕГ-ын Хууль, Эрх зүйн хэлтэс нь хяналт тавин ажилласан. Мөн тухайн удирдлагын шийдвэр нь авлига авах нөхцөл бүрдүүлсэн эсэх, бусдад давуу эрх боломж олгосон эсэхийг давхар хянаж ажилласан.<br>2. 2014 онд ГЕГ-ын даргын батлан гаргасан нийт 180 орчим тушаал шийдвэр, гаалийн газар хороодын удирдлагын батлан гаргасан 300 орчим тушаал шийдвэрийг хянан ажилласан.<br>ГЕГ-ын даргын батлан гаргасан тушаал шийдвэр нь хэм хэмжээ тогтоосон, эрх олгосон, үүрэг болгосон бол түүнийг тухай бүр Үндэсний болон арилжааны телевизээр дамжуулан нийтэд түгээн ажилласан. 2014 онд нийт давхардсан тоогоор 300 орчим удаа телевизийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл түгээн ажилласан.<br>Гаалийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд ил тод нээлттэй хүргэн ажиллах ажлын хүрээнд гэрээ байгуулсан 26 гаруй телевиз, 9 цахим хуудас болон 8 сонины газарт мэдээ, мэдээлэл өгч хамтран ажиллаж байна. |
| | | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа байршуулах | | Гаалийн албаны хуучин www.ecustoms.mn цахим хуудсыг бүрэн шинэчлэн www.customs.gov.mn өөрчилж, гаалийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үндсэн болон туслах цэсүүдийг нээж тухай бүр шинэ мэдээ, мэдээллийг оруулж байна. Уг цахим хуудсанд гаалийн байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэр, гаалийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зоригоор 2014 оны эхний хагас жилийн байдлаар 183, жилийн эцсийн байдлаар 300 гаран мэдээ, мэдээлэл оруулсан байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийг цахим хуудсандаа байршуулах | | Төлбөр, хураамжийн жагсаалтыг цахим сайтад байршуулсан.<br>Зураг-54<br><br> |
| 7.1.14 | Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11;<br>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2;<br>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3;<br>• Иргэдээс төрийн байгууллага | Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчилсан байх | 0-4 | ГЕГ-ын даргын батлан гаргасан тушаал шийдвэр нь хэм хэмжээ тогтоосон, эрх олгосон, үүрэг болгосон бол түүнийг тухай бүр Үндэсний болон арилжааны телевизээр дамжуулан нийтэд түгээн ажилласан.<br>2014 онд нийт давхардсан тоогоор 300 орчим удаа телевизийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл түгээн ажилласан.<br>Гаалийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд ил тод нээлттэй хүргэн ажиллах ажлын хүрээнд гэрээ байгуулсан 26 гаруй телевиз, 9 цахим хуудас болон 8 сонины газарт мэдээ, мэдээлэл өгч хамтран ажиллаж байна. |
| | | Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр) | | 2014 оны 10 сарын 30-ны өдрийн байдлаар гаалийн ерөнхий газарт өргөдөл хүсэлт ирснээс хариутай 988, хариу өгсөн 963, хугацаа болоогүй 25 өргөдөл байна. Нийт 32 гомдол ирсэнээс 28 гомдолын хариуг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, хугацаа болоогүй судлагдаж байгаа 4 гомдол байна.<br>Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг байгууллагын бичиг хэргээр бичгээр, 1800-1281, ЗГ-ын 11-11-т амаар, санал хүсэлтийн хайрцаг, факс зэрэгт бичгээр авч байна. Хэрэгжилтийг цахим сайтад байршуулсан.<br>Албан хэрэг хөтлөлттэй холбоотой хууль тогтоомж, албан хэрэг хөтлөлтийн заавар, баримт бичгийн стандарт, өргөдөл, гомдол, санал, хүсэлт хүлээн авах, шат дамжлагыг бууруулах зорилгоор нийт ажилтнуудын анхааралд зориулж “Мэдээллийн цаг”-аар мэдээлэл хийж эдгээртэй холбоотой мэдээллийг “Албан бичиг хэрэг” самбарыг байршуулсан.<br>МТТ-тэй хамтран бичиг хэргийн програмыг боловсронгуй болгох хурдыг нэмэгдүүлэх, мэдээ тайланг үнэн зөв гаргах зарим үзүүлэлтээр мэдээг нэмж |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 8, 9 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг | | | гаргадаг болгон ажиллаж байна.<br>Иргэдийн өргөдөл гомдол хүсэлтийг шийдвэрлэсэн талаарх мэдээллийг “Цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах” арга хэмжээний хүрээнд гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны шуурхай, ил тод байдлыг хангах зорилгоор Улаанбаатар хот дахь гаалийн газар, Замын-Үүд дэх гаалийн газруудад “Ухаалаг LED дэлгэц” байршуулсан. Тус ухаалаг дэлгэцэнд:<br>• Гаалийн байгууллагын цахим хуудас<br>• Хил орчмын үнийн судалгаа<br>• Автомашины интернэт үнийн судалгаа<br>• Бүрдүүлэлтийн явц<br>• Валютын ханш болон БТКУС-ын талаархи мэдээллүүдийг тус тус байршуулсан.<br>Зураг-55<br><br>Мөн гаалийн байгууллагаас гадаад худалдаа эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд импорт, экспортын лавлагаа, Гаалийн байгууллагад татварын өртэй эсэх талаархи тодорхойлолтыг ТҮЦ машинаар гаргах боломжийг бүрдүүлсэн. Одоогоор Гаалийн байгууллагад татварын өртэй эсэх талаархи тодорхойлолтыг ТҮЦ машинаар гаргах үйлчилгээг нэвтрүүлээд байна. 2014-07 сард 332, 2014-08 сард 275, 2014-09 сард 220 ширхэг тодорхойлолт хэвлээд байна. |
| | | Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн | | Гаалийн байгууллагын үйлчилгээ, захидал харилцаа, бичиг хэргийн асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн |

<table>
<tr>
<td rowspan="2"></td>
<td rowspan="2"></td>
<td>эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах</td>
<td rowspan="2"></td>
<td>хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулсан.<br>Зураг-56
<table>
<tr><td>12.</td><td>Ц.Нямбаяр</td><td>Даргын туслах</td><td>- Удирдлагын шуурхай хуралдааны тов, хэлэлцэх асуудлын талаарх мэдээлэл хүргэх, бэлтгэл зохион байгуулалтыг хангах, хуралдааны явцын тэмдэглэл хөтлөх<br>- Шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг, даалгаврыг холбогдох ажилтанд хүргэх, Захиргаа, дотоод ажлын систем программд оруулах, биелэлтийг хариуцах ажилтнуудаас гаргуулан авч нэгтгэх, удирдлагад танилцуулах</td></tr>
<tr><td>13.</td><td>Б.Энхжаргал</td><td>ГУБ</td><td>- Бичиг хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу байгууллагад ирсэн баримт бичгийг хүлээн авч, бичиг хэргийн программд бүртгэн тэмдэг дарж, холбогдох албан тушаалтанд хүргэх<br>- Байгууллагаас явуулах бичиг баримтыг хүлээн авч бүртгэл хөтлөн холбогдох байгууллагад хүргүүлэх<br>- Хариутай бичгийн хөтлөлтөд хяналт тавин холбогдох газар, хэлтсээс гаргуулан авах<br>- Байгууллагаас явуулсан бичиг баримтыг бүртгэн архивт өгөх<br>- Байгууллагын албан бланкуудыг хэвлүүлж дугаарлах, зарцуулалтад хяналт тавьж, ашиглалтыг сайжруулах<br>- Харъяа гаалийн газар, хороодын бичиг хэргийн ажилтнуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, албан хэрэг хөтлөлтийн талаарх лавлагаа, зөвлөмж мэдээлэл хүргүүлэх, сургалт явуулах</td></tr>
<tr><td>14.</td><td>Д.Наранцэцэг</td><td></td><td>- Гаалийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн заавар журмын биелэлтэд хяналт тавьж, заавар зөвлөгөө, удирдамж чиглэлээр хангах<br>- ГЕГ-ын ББНШК-ыг байгуулах, устгах хэргийн актыг Үндэсний төв архивын дэргэдэх ББНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах<br>- Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу ажилтнуудаас баримт материалыг хүлээн авах, байнгын болон түр хадгалах баримт материалыг бүртгэн төрөлжүүлж холбогдох журмын дагуу арга хэмжээ авах</td></tr>
</table>
</td>
</tr>
<tr>
<td>Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлсэн байх</td>
<td>Засгийн газрын “Эдийн засгийг эрчимжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд болон Гаалийн байгууллагын авлигын эсрэг зохион байгуулж буй үйл ажиллагааг олон нийтэд сурталчилах, төрийн байгууллагын хүнд суртал шат дамжлагыг цөөрүүлж арилгах, төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй түргэн шуурхай болгох зорилгоор Гаалийн ерөнхий газар болон түүний харьяа гаалийн газар, хороодын зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн баталсан. Үүний хүрээнд Гаалийн байгууллагын удирдах, дунд шатны шийдвэр гаргагч дарга нарын тоог 106-р цөөлсөн шийдвэр хэрэгжиж эхэлсэн. Энэ шийдвэр нь удирдлагын зардлыг бууруулж, төсвийг дорвитой хэмнэх боломжийг бүрдүүлж байна.</td>
</tr>
<tr>
<td>7.1.15</td>
<td>Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах<br><br>Эрх зүйн үндэслэл:<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12;</td>
<td>Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах, уг жагсаалтыг гаргахдаа тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурласан байх</td>
<td>0-2</td>
<td>Авлигад өртөх эрсдэлтэй ажил албан тушаалтанд Гаалийн улсын байцаагч бүр албан тушаалын хувьд хамаарч байгааг ГЕГ-ын Төрийн захиргаа удирдлагын газраас 2013 онд судлан тогтоосон. Өөрөөр хэлбэл ГУБ бүр албан үүрэг гүйцэтгэх явцдаа бараа тээврийн хэрэгсэлд биет үзлэг шалгалт хийж улсын хилээр оруулах гаргах эсэх тухай бие даан шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан юм. Гаалийн тухай хуулийн 274 дүгээр зүйл.</td>
</tr>
</table>

| | | | | |
|---|---|---|---|---|
| | • Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 | Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, мэдэгдэл гаргах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг хэрхэн зохион байгуулсан г.м/ | | 1. "Гаалийн улсын байцаагчийг сэлгэн ажиллуулах журам", гаалийн улсын байцаагчийг сэлгэн ажиллуулахад байгуулах гэрээ, гэрээний биелэлтийг дүгнэх хуудсыг боловсруулж, ГЕГ-ын даргын 06 дугаар сарын 14-ний өдрийн А/106 тоот тушаалаар батлагдсан.<br><br>2. Харьяа гаалийн газар, хороодод эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагч ажиллуулах "Албаны эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагчаар ажиллах гэрээ"-г шинэчлэхээр төслөөр бэлтгэж удирдлагад танилцуулсан.<br><br>ГЕГ-ын даргын тушаалыг дотоод сүлжээ болон гаалийн байгууллагын цахим хуудасны Хүний нөөцийн ил тод байдлын санд байршуулсан.<br><br>Мөн Гаалийн улсын байцаагчийг өөрийн хүсэлт болон албан хаагчдын судалгааг үндэслэн, харьяа удирдлагын зөвлөлийн гишүүд болон хамт олны санал дээр тулгуурлан сэлгэн ажиллуулж байна. Энэ талаарх мэдээллийг удирдлага дотооддоо онлайн хурал болон мэдээллийн цагаар, олон нийтэд хэвлэл мэдээлэлийн ил тод байдлыг хангах үүднээс мэдээлэл хийж ажилладаг. |
| 7.1.16 | Төрийн байгууллагын байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлахыг хориглоно.<br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.4;<br>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 | | 0-1 | ГЕГ-ын хувьд байхгүй ба гаалийн газар,хороодын хувьд өөрийн албан байр, төрийн байгууллагын ажлын байрыг дараах 2 төрлийн субьектэд хуулийн дагуу ашиглуулж байна. Үүнд: 1.Гаалийн зуучлагч байгууллага,<br>2.Банкны салбар<br>Гаалийн зуучлагч байгууллага нь Гаалийн тухай хуулийн 66-70 дугаар зүйлд заасан эрх зүйн зохицуулалтын дагуу үйл ажиллагаа эрхэлдэг бол, Гаалийн үйлчилгээг нэг цонхны системд шилжүүлэх, худалдааны саад тотгорыг арилгах, мэдүүлэгчийн цаг хугацаа зардлыг хэмнэх зорилгоор Банкны байгууллагыг Гаалийн байгууллагын байранд үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрдөг.<br>Дээрх байгууллагуудыг түрээсээр үйл ажиллагаа эрхэлсэний орлогыг Төрийн санд бүрэн шилжүүлэн ажиллаж байна. |
| 7.1.17 | Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, 6.7, 18 дугаар зүйлийн 18.4.2, 29 | Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмжийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ | 0-5 | АТГ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу хууль хэрэгжүүлж, зөвлөмжийг мөрдөн авлигын эсрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллав.<br>1. ГЕГ-т ирүүлсэн зөвлөмжийн дагуу 2014 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллав<br>2. АТГ-аас 03/7007, 01/3378 дугаар албан бичгээр ирүүлсэн хуулийн хэрэгжилтийг хантан ажиллав |
| | | АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | дүгээр зүйлийн 29.4;<br>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 | шалтгаан нөхцөлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийн биелэлт, зохион байгуулсан арга хэм-жээ<br>АТГ-аас зөрчил арилгуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ<br>АТГ-аас хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт<br>Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн дүрэм, журам, заавар, шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгосон эсэх<br>АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам"-ыг хэрэгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээ | | Авлигатай тэмцэх газраас аливаа шийдвэр хүргүүлээгүй тохиолдолд бүтэн оноо өгч үнэлэх<br>/АТГ-аас мэдээллийг өгөх/ |
| **7.2.Авлигатай тэмцэх санал, санаачилга** | | | | |
| Дэд хэсэг | Хийх ажлын агуулга | Шалгуур<br>Гүйцэтгэлийн үзүүлэлт | Оноо 0-30 | Тайлбар |
| 7.2.1 | Авлигын эсрэг соён гэгээрүү-лэх, авлигатай тэмцэх, урьд-чилан сэргийлэх арга хэм-жээг боловсруулж хэрэгжүү-лэх | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжүүлсэн байх | 0-5 | Гаалийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөөг АТГ-аас боловсруулсан "Төрийн байгууллагуудаас авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлал"-ын шалгуур үзүүлэлт, загвар төлөвлөгөөг үндэслэн боловсруулсан.<br><br>Төлөвлөгөөний төсөлд ГЕГ-ын газар, хэлтсүүд болон АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн саналыг авсан. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | ***Эрх зүйн үндэслэл:***<br>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 7.6.1, 7.6.2; | | | ГЕГ-ын даргын 2014 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/26 дугаар тушаалаар Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулсан. “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г боловсруулан Гаалийн ерөнхий газрын даргын А/36 тоот тушаалаар батласан.<br>Төлөвлөгөөг:<br>- Ёс зүйтэй манлайлал,<br>- Хувь хүний шударга байдал,<br>- Тогтолцооны шударга байдал,<br>- Хяналт шинжилгээ болон таслан зогсоох гэсэн үндсэн 4 тулгуур зарчмын хүрээнд 22 зорилттой, 52 ажил хийхээр тусгагдсан.<br>Уг төлөвлөгөөнд тулгуурлан харьяа гаалийн газар, хороо бүр байгууллага, орон нутгийн онцлогт тохируулан авлигын эсрэг төлөвлөгөөтэйгээр ажилласан. ГЕГ-аас газар, хороодод чиглэл өгч удирдлагаар хангасан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин, гүйцэтгэлийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллаж байна.<br>http://www.customs.gov.mn/2014-03-24-06-24-11/2014-03-24-06-25-21/2014-05-22-06-04-03 |
| | | Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ цаг, хугацаандаа хэрэгжсэн байх | | Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хуваарилсан хугацаандаа хэрэгжүүлэн ажиллав. |
| | | Хэрэгжилтийн тайланг тогтсон хугацаа /жил бүрийн 11 сарын 15-ны дотор/-нд АТГ-т хүргүүлсэн байх<br>Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг тайланд тусгасан байх | | Хэрэгжилтийн тайланг 2014 оны 11 сарын 14-ны өдөр ТЗУГ-ын 04/4232 тоот албан бичгээр АТГ-т хүргүүлсэн. |
| 7.2.2 | Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт | Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хэвийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал санаачилга /уриа, уриалга, мэдэгдэл, амлалт г.м/-д нэгдсэн байдал | 0-15 | “Авлигагүй гааль” уриалгын хүрээнд гаалийн ерөнхий газрын 4 газрын 10 хэлтэс болон дэргэдэх 7 байгууллага, 18 гаалийн газар, хороодын хүрээнд хамтран ажилласан. Уг уриалгад гаалийн байгууллагын хэмжээнд нэгдэн зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллаж чадсан.<br>Гаалийн байгууллага болон сэтгүүлчдийн эвлэлтэй хамтран “Зангиагүй уулзалт”-ыг анх удаа 2014 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан. Уг зангиагүй уулзалтад хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлч нарыг төлөөлж МОНРТ, Ийгл телевиз, ТМ телевиз, Үнэн сонин, Улс төрийн тойм сонин, Zaluu.com, Batar.mn, gogo.mn зэрэг нийт 53 телевиз, сонин, цахим хуудсын төлөөлөл, сэтгүүлчид оролцсон. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | Гаалийн байгууллага нь МХАҮТ-тай хамтарсан “Гааль Бизнесийн зөвлөлдөх уулзалт-2014 он”-ыг зохион байгуулсан.<br>Сангийн яамнаас ирсэн 8-1/1629 тоот албан бичгийн дагуу 2014 оны 5 дугаар сарын 3, 4-ны өдөр “Чингисийн талбай”-д Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг сурталчилах, яамдаас салбарын хэмжээнд явуулж байгаа бодлого, үйл ажиллагааг мэдээлэх, сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлагийн зүгээс иргэдэд үзүүлж байгаа ажил, үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг таниулан мэдээлэх зорилгоор иргэдэд мэдээлэл, сурталчилгаа, үйлчилгээ зохион байгуулахаар “Нээлттэй өдөрлөг”-ийг ГЕГ-ын ХЭЗХ, ГХБХ, ГЗТХ, ЭУХ, БДШГ, ГТЛ, МТТ, ЭНСТөв болон Улаанбаатар хот дахь гаалийн газар, Буянт-Ухаа дахь гаалийн газар, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрууд өөрийн чиг үүргийн дагуу оролцсон.<br>“Авлигаас урьдчилсан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигаас ангид байх” зорилгоор Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс ирүүлсэн “Төлөөс“ теле жүжгийг ГЕГ болон гаалийн газар, хороодын нийт Гаалийн улсын байцаагч нарт үзүүлж танилцуусан. |
| | | Удирдах алба тушаалтнуудын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт, санаачилга, тэдний үлгэр жишээ байдал | | Гаалийн ерөнхий газрын дарга О.Ганбат, дэд дарга Н.Энхцогт, дэд дарга Ц.Уугангэрэл, Төрийн захиргаа удирдлагын газрын дарга О.Даваасүрэн, Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ болон Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар Н.Ганболд, Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга Б.Бат-Отгон, Хяналт шалгалт дүн шинжилгээний хэлтсийн дарга Ж.Батсайхан нар АТГ-т 2014 оны 04 сарын 02-ны өдөр “Гаалийн байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, хүчин чармайлт”-ын хүрээнд уулзалт зохион байгууллаа. Удирдлагын зүгээс “Авлигагүй гааль” уриалга гаргасан. |
| | | Авлигын эсрэг арга хэмжээнд зориулан тусгайлан хөрөнгө гаргасан эсэх /зарцуулалт/ | | ГЕГ-ын авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг төсөвт “төлбөр, хураамж болон бусад зардал” гэсэн эдийн засгийн ангилалаас санхүүжүүлэн ажиллаж байна.<br>Авлигын эсрэг үйл ажиллагаатай дараах ажлуудыг санхүүжүүлээд байна. Үүнд:<br>- Төсөв санхүүгийн мэдээллийн самбар хийлгэн ГЕГ-ын 1 давхарт байрлуулаад байна. Дээрх самбарыг 260,000 төгрөгөөр худалдан авсан.<br>- “Авилгагүй гааль” уриалгын материал худалдан авсан. Үүнд 26,000 төгрөг зарцуулав.<br>- “АХА” таавaрт тэмцээн зохион байгуулахад 283,000 төгрөг,<br>ГЕГ-ын давхар бүрт байрлуулсан 5 ширхэг мэдээллийн LED дэлгэц худалдан авахад 3,778,500 төгрөгийг тус тус зарцуулаад байна. |
| | | Удирдлагын хүсэл, эрмэлзлэл, хүчин чармайлт, үлгэр жишээ байдлын талаар | | “Шинжээчдийн баг”-аас тусгай-лан боловсруулсан санал асуулгаар үнэлэх |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | ажилтнуудаас өгсөн үнэлгээ | | |
| 7.2.3 | Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх | Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ /шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг, зөвлөмж өгөх г.м/-г авах | 0-10 | Гаалийн ерөнхий газрын дарга О.Ганбатын урилгаар Австралийн Гриффитийн Их сургуулийн доктор, профессор Чарльз Сампфорд 2014 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Гаалийн ерөнхий газарт хүрэлцэн ирж “Авлига, Ариун шударга ёс, Гаалийн байгууллага” сэдвээр лекц уншлаа. Энэхүү лекцэд ГЕГ-ын харьяа Улаанбаатар хот дахь Гаалийн газар, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар, Буянт-Ухаа дахь гаалийн газар болон Сургалтын төвийн Гаалийн улсын байцаагч нар оролцож, дэлхий нийтийн “Ариун шударга ёс” ба “Авлига” сэдвээр хамгийн сүүлийн үеийн онолын болон практикийн мэдээ, мэдээлэл хүлээн авлаа.<br>Зураг-57<br><br>Мөн Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шижилгээний хэлтсийн ажилтан, комиссар Н.Өлзийг 2014 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Гаалийн ерөнхий газарт урьж харъяа гаалийн газар хороодын Эрх бүхий албан тушаалтнуудад цахимаар /online/ сургалт хийсэн бөгөөд, 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр тус хэлтсийн ажилтан, комиссар Л.Анхныбаяр Гаалийн ерөнхий газар, Улаанбаатар хотын гаалийн газрын албан тушаалтнуудад хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлэг хэрхэн бөглөх тухай сургалт зохион байгуулж сургалтанд байгууллагын нийт албан хаагч бүрэн хамрагдсан ба ХАСХОМ-ийг хэрхэн бөглөх, ямар асуудал дээр анхаарах, нийтлэг гаргадаг алдаа дутагдал зэрэг холбогдох мэдээллийг өгсөн.<br>Авлигатай тэмцэх газар, нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн, АНУ-ын олон улсын хөгжлийн агентлаг, АНУ-ын Азийн сан хамтран 2014 оны 02 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан “Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах нь сургалт”-нд гаалийн байгууллагаас 30 албан хаагч хасрагдав.<br>Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | ахлах ажилтан, ахлах комиссар Д.Мөнхжаргал нь Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн талаарх сургалтыг 2014 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр Гаалийн ерөнхий газар болон түүний дэргэдэх байгууллагуудын гаалийн улсын байцаагч нарт амжилттай зохион байгуулсан.<br>Уг сургалтыг монтажлан гаалийн газар, хороонд https://www.youtube.com/user/mongoliancustoms цахим сайт дээр 0J8A1772, 0J8A1776, 0J8A1777, 0J8A1778 гарчигтайгаар 4 хэсэгт хуваан байршуулсан. Гаалийн газар, хороодын дарга нар уг хичээлийг нийт гаалийн улсын байцагч нарт үзүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг дотооддоо хийхээр шийдүүлсэн.<br>АТГ-аас хүргүүлсэн “Авлигаас урьдчилсан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигаас ангид байх” зорилгоор Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс ирүүлсэн “Төлөөс“ теле жүжгийг ГЕГ-ын нийт Гаалийн улсын байцаагч нарт үзүүлж танилцуусан. Энэхүү теле жүжгийг харьяа 18 газар, хороодод DVD хэлбэрээр хүргүүлж нийт гаалийн улсын байцаагч нарт үзүүлэн танилцуулав.<br>2014 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Улаанбаатар дахь гаалийн газарт гаалийн улсын байцаагч нар дунд Авлигын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчлан сэргийлэх тухай хууль, Гаалийн улсын байцаагчийн сахилгын дүрмээр асуулт хариултын “АХА” тэмцээн зохион байгуулав.<br>Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газарт ГЕГ-ын ЭБАТ ГУБ Р.Болормаа газрын нийт гаалийн улсын байцаагч нарт заавар зөвлөмж, хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгийн талаар дэлгэрэнгүй мэдээллээр ханган ажилласан болно.<br>Хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах, авлигаас ангид байлгах урьдчилан сэргийлэх үүднээс гаалийн байгууллагын дотоод сүлжээ болох CERP, SPARK messenger-ийг ашиглан гаалийн байгууллагын нийт гаалийн улсын байцаагч нарт Авлигын эсрэг хууль болон холбогдох хууль тогтоомж, мэдээ мэдээллийг өгч ажилласан.<br>“Авлига үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх нь” онол-практикийн бага хурал ГЕГ-ыг төлөөлж ЗХНХ-ийн дарга Д.Бат-Эрдэнэ, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийн хэрэгжилт, нөхцөл байдлын илтгэл тайлант хуралд ЗХНХ-ийн гаалийн улсын байцаагч оролцов. |
| | | Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авсан арга хэмжээ | | ГЕГ-ын болон харьяа гаалийн газар, хороодын албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааны талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулсан.<br>http://www.customs.gov.mn/2014-03-24-06-24-11/2014-03-24-06-24-38/2014-06-03-04-08-03/431-2014-11-14-12-58-42 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчил, авсан арга хэмжээ | +10 | Гаалийн байгуулага нь байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын дагуу төлөвлөгөөт шалгалтуудыг хийсэн. ГЕГ-ын нэгж, дэргэдэх байгууллага, гаалийн газар, хороодын үйл ажиллагааг улирал бүрээр, гаалийн байгууллагад ажиллагсдын сэтгэл ханамжийн судалгаа, гаалийн байгууллагаар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа, нээлттэй өдөрлөгөөр авсан санал асуулгын судлагаа зэрэгт дотоод аудит, шалгалт хийсэн. Энэ шалгалтын хүрээнд авлигын зөрчил, авсан арга хэмжээ байхгүй болно.<br>Зураг-58<br><br> |
| | | Бусад байгууллага, иргэдийн гомдлоор илэрсэн зөрчил, авсан арга хэмжээ | -5 | Бусад байгууллага, иргэд байгууллагын өргөдөл, гомдлоор үүсгэгдсэн авлигатай холбоотой хэрэг зөрчил Гаалийн байгууллагын хэмжээнд 2014 онд байхгүй болно. |
| | | Шүүхээр шийдэгдсэн Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн авлигын гэмт хэрэг ба бусад зөрчил | -5 | Шүүхээр шийдэгдсэн Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн авлигын гэмт хэргийн зөрчилгүй болно. |

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР